



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН 2018

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН
БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛАХДАА
САНХҮҮЖИХ ДУНДАЖ ХҮҮХДИЙН ТОО, НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ
ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫГ БАРИМТЛААГҮЙ
БАЙНА.**

**АУДИТЫН НЭР: ХЭНТИЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ**

АУДИТЫН КОД: ХЭА-2018-04-ГА

Агуулга		
Аудитыг гүйцэтгэсэн: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар Аудитын менежер Д.Оюунтуяа Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг Аудитор Ц.Энхтүвшин Ц.Хатанболд 2018 он 04 сарын 06 Холбоо барих: Утас 7056-2112 Цахим хаяг khentii@audit.gov.mn Байршил Хэнтий аймаг Хэрлэн сум Чингис хот Аймгийн ЗДТГ-ын байр 320 тоот	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
	АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА	3
	АУДИТЫН ДҮН	4
	БҮЛЭГ 1: Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагуудын төсвийн төсөл үндэслэл муутай боловсруулагдаж, хянагдсан байна	5
	1.1 Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлахгүй байна.	5
	1.2 Аймгийн боловсрол, соёл, урлагийн газар нэгж байгууллагын төсвийг хянахдаа санхүүжих дундаж хүүхдийн тоонд суурилагагүй байна.	9
	БҮЛЭГ 2: Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт үндэслэл муутай хуваарилагдсан байна.	12
	2.1 Сангийн сайдын баталсан төсвийн эдийн засгийн ангиллын хувь хэмжээнд өөрчлөлт оруулж хуваарилсан байна.	12
	2.2 Төсөвт зохицуулалт хийхдээ судалгаа, шинжилгээ хангалтгүй хийж, бодит тооцоололд үндэслээгүй байна.	13
	БҮЛЭГ 3: Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтэд тавих хяналт хангалтгүй байна.	16
	3.1 Цэцэрлэгийн болон дотуур байрны хүүхдийн хоолны зардал, “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтийг хэмнэх боломж байна.	16
	3.2 Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативт зардлын санхүүжилтийг аймгийн Боловсрол соёл, урлагийн газар сар бүр хүүхэд өдрөөр хянаагүй байна.	17
	АУДИТЫН ДҮГНЭЛТ	18
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	18
	АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	19
	Тайлангийн төсөлд ирүүлсэн санал ба тайлбар	19
	Тайланг баталгаажуулсан шийдвэр	21
ХАВСРАЛТ	22	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР		
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын Стандарт	
УИХ	Улсын их хурал	
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч	
ТШЗ	Төсвийн шууд захирагч	
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан	
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан	
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар	
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль	
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол	
НТБ	Насан туршийн боловсрол	
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар	
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл	
СДХ	Санхүүжих дундаж хүүхэд	
ХЗДН	Хувьсах зардлын дундаж норматив	

АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 01 сарын 05 өдрийн А/05 тушаалыг үндэслэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт ба зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж, хянасан эсэх
- Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт хүртээмжтэй, үндэслэлтэй хуваарилагдсан эсэх
- Боловсролын салбарын төсвийн зарцуулалт үр дүнтэй эсэх

Аудитад аймгийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол олгох сургалтын байгууллагуудын төсвийн төсөл, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын хянасан, хуваарилсан баримт материал, 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт материалыг хамруулав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- “Төсвийн тухай” хууль
- “Боловсролын тухай” хууль
- “Төрийн албаны тухай” хууль
- Засгийн газрын 2012 оны 106-р тогтоол “Хоолны зардлын дундаж норматив”
- Засгийн газрын 2016 оны 242-р тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал”
- Засгийн газрын 2006 оны 194-р тогтоол “Үдийн цай хөтөлбөр”
- БШУ-ны сайд 2010 оны №256 Төсвийн төслийн маягт
- БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайд 2007 оны №307/91/237 -Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”
- Сангийн сайд 2013 оны 73-р тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”
- Засгийн газрын 2007 оны 354-р тогтоол “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”

Аудитыг гүйцэтгэхэд аудитын удирдамж АДБОУС 3000, 3100-ийг ашиглан “Төрийн хяналт шалгалтын стандарт”, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан төсвийн төлөвлөлт, хуваарилалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тодруулга авсны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, асуудал бүрээр судалгаа гарган дүн шинжилгээ хийж, санхүүгийн баримтыг тулган баталгаажуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөсөн хугацаанд батлуулан аудитын сэдэв, зорилттой холбогдолтой нотлох зүйл цуглуулах ажлыг 5-р сарын 28-ыг хүртэл, цуглуулсан баримт, судалгааг нэгтгэн дүн шинжилгээ хийх ажлыг 6-р сарын 16-ыг хүртэл хийж гүйцэтгэв. Аудитын тайлагнах үе шатны ажлыг 06-р сарын 11-нөөс эхлэн, тайланг 2018 оны 06-р сарын-ны өдөр Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлд танилцууллаа.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Д.Оюунтуяа аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлаж, аудитор Ц.Энхтүвшин. Ц.Хатанболд нар аудитын хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудит хийх хугацаанд нэгж байгууллагууд төсвийн төслийг нэг бүрчлэн нягталж, мэдээллийг цуглуулах, зарим лавлагаа мэдээллийг тодруулах хугацаанд БСУГ-ын мэргэжилтэн хүндэтгэх шалтгаантай байсан нь нотлох баримтыг судлах, нэгтгэн дүгнэхэд цаг хугацаа их орсныг тэмдэглэж байна.

АУДИТЫН ДҮН

Хэнтий аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсрол олгох төрийн өмчит 32, хувийн хэвшлийн 2 хүүхдийн цэцэрлэг, бага, дунд боловсрол олгох төрийн өмчит 25, хувийн хэвшлийн 1 сургууль, тусгай хэрэгцээт боловсрол олгох 1 төв, нийт 61 сургалтын байгууллага ажиллаж байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургалтад 13818, албан бус боловсролын боловсролын сургалтад 404 хүүхэд хамрагдаж, боловсролын стандартыг хангахад 801 багш, цагийн 16 багш, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад 415 ажилтан, гэрээт 22 галч ажилласан байна. Харин 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургалтад 14191, албан бус боловсролын боловсролын сургалтад 349 хүүхэд хамрагдаж, боловсролын стандартыг хангахад 729 багш, цагийн 4 багш, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад 392 ажилтан ажиллажээ.

Хэнтий аймгийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд 36 удирдах ажилтан, 189 бүлгийн болон бусад багш, 175 туслах багш, 264 үйлчилгээний ажилтан, 39 гэрээт ажилтан, 2017-2018 оны хичээлийн жилд 35 удирдах ажилтан, 212 бүлгийн болон бусад багш, 178 туслах багш, 240 үйлчилгээний ажилтан, 46 гэрээт ажилтан ажиллаж СӨБ-ын үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын БСШУС-ын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнд ерөнхий боловсролын ТШЗ-ийн санхүүжилтийг 2017 онд 17604.7 сая төгрөг, 2018 онд 18349.9 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын ТШЗ-ийн санхүүжилтийг 2017 онд 8547.6 сая төгрөг, 2018 онд 8870.8 сая төгрөг байхаар тус тус тусгажээ.

Аймгийн БСУГ-аас хүргүүлсэн төсвийн төслийн саналыг БСШУСЯ, Сангийн яам хянаж 2017 онд 2246.6 сая төгрөг, 2018 онд 455.4 сая төгрөгөөр, СӨБ-ын байгууллагын төсвийн саналыг 2017 онд 295,9 сая төгрөг, 2018 онд 698,6 сая төгрөгөөр тус тус бууруулан 2017 онд 26,764.5 сая төгрөг, 2018 онд 27,220.7 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг хуваарилсан байна.

Аймгийн ЕБС-иуд өөрийн үйл ажиллагаанаас 2017 онд 15.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэр батлуулжээ.

Аймгийн хэмжээгээр 2017 онд ерөнхий боловсролын сургалтад 18079,8 сая төгрөг зарцуулж, 22,9 сая төгрөг төвлөрүүлсэн бол СӨБ-ын үйлчилгээнд 2017 онд 8666,5 сая төгрөг зарцуулж 23,8 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ ҮНДЭСЛЭЛ МУУТАЙ БОЛОВСРУУЛАГДАЖ, ХЯНАГДСАН БАЙНА.**1.1 НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫГ БАРИМТЛАХГҮЙ БАЙНА.****А. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР**

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 5 сарын 2-ны өдрийн 242 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, 2 дугаар хавсралтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тус тус тогтоосон байна.

Аймгийн СӨБ-ын байгууллагуудын төсвийн төслийг дээрх тогтоолын дагуу тооцон үзэхэд 2017 онд 6489 хүүхэд суралцах, цалингийн санд 4194.7 сая төгрөг, бусад хувьсах зардалд 142.6 сая төгрөг, 2018 онд 6572 хүүхэд суралцах, цалингийн санд 4245,8 сая төгрөг, бусад хувьсах зардалд 144,6 сая төгрөгийг тус тус зарцуулахаар байна.

Дээрх тооцоололтой СӨБ-ын байгууллагуудаас ирүүлсэн төсвийн төслийг харьцуулж үзэхэд 2017 онд цалингийн санг 495 сая төгрөгөөр, бусад хувьсах зардлыг 6,1 сая төгрөгөөр, 2018 онд цалингийн санг 659,6 сая төгрөгөөр тус тус илүү тооцож төлөвлөсөн нь төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа арга хэмжээгээр бус эдийн засгийн ангиллаар төлөвлөсөнтэй холбоотой байна.

СӨБ-ын байгууллагууд төсвийн төслөө боловсруулахдаа суурь үзүүлэлтийг ашигладаггүй, өмнөх оны гүйцэтгэл болон тухайн жилийн элсэлттэй уялдуулан тооцож төсвийн төслөө боловсруулсан ч 2017 онд СӨБ-д нийт хамрагдвал зохих хүүхдийн 93 хувь, 2018 онд 91 хувь нь СӨБ-д хамрагдаж байгаа нь хамрагдвал зохих хүүхдийг бүрэн хамруулах боломжгүй байгаатай холбоотой байна. Мөн сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг баримтлалгүй, цалингийн санг орон тоогоор тооцсон, СӨБ-ын байгууллагуудын 46,8 хувь нь бусад хувьсах зардлын тогтоосон хэмжээг баримтлаагүй нь төсвийг илүү төлөвлөх шалтгаан болжээ.

Хууль эрх зүйн шинэчлэл, ажилтан албан хаагчдын цалингийн өөрчлөлтөөс шалтгаалж төсвийн төсөл бодитой бус болох магадлалтай тул хувьсах зардлаар тооцсон цалин болон тогтоосон цалинг харьцуулан төсвийн төслийн танилцуулгад оруулж байх шаардлагатай байна.

Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

ЕБС-иуд 2017 18484.7 сая төгрөг, 2018 онд 17844.9 сая төгрөг төсөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 2017 онд 1139.9 сая төгрөгөөр өсөж, 2018 онд 206.3 сая төгрөгөөр буурчээ.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 3, 4 дүгээр хавсралт, БСШУ-ы сайд, Сангийн сайдын 2007 оны 306/237 дугаар хамтарсан тушаалаар баталсан итгэлцүүрээр санхүүжих дундаж хүүхдийг тооцох заавар¹-ын дагуу тооцоход ЕБС-иуд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар төлөвлөх зардлуудыг 2017 онд 1545.9 сая төгрөг, 2018 онд 1455.5 сая төгрөгөөр илүү тооцож төсвийн төсөл боловсруулсан нь санхүүжих дундаж хүүхдийн тоог буруу тооцоолж, хувьсах зардлын дундаж нормативыг баримтлаагүйгээс шалтгаалжээ.

¹ “Байгууллагын төсөв санхүүгийн төлөвлөлт, удирдлагын арга зүй” 2015 номын 133-р хуудас.

**НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ
НОРМАТИВ, ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦОХ ЗАРДАЛ**

(сая төгрөгөөр)

№	Арга хэмжээ	2017 онд			2018 онд			СДХ	ХЗДН
		ЕБС	АУДИТ	зөрүү	ЕБС	АУДИТ	зөрүү		
1	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ (АБ-2, 3)	6895.3	6044.1	1046.9	6777.6	6124.8	954.5	✓	✓
2	Дотуур байрны зардал (АБ-4)	683.7	404.9	278.8	662.9	376.1	286.8	✓	✓
3	Дотуур байрны хоол (АБ-4)	938.3	703.5	234.8	868.4	644.8	223.6		
4	Орой, эчнээ сургалтын зардал (АБ-5)	42.0	56.6	-14.6	36.6	46.0	-9.4	✓	✓
	Нийт дүн	8559,3	7209,1	1545,9	8345,5	7191,7	1455,5		

Санхүүжих дундаж хүүхдийг 2017 онд 22 сургууль 650, 2018 онд 21 сургууль 740-өөр илүү тооцсон нь дээрх үзүүлэлтүүдийг буруу тооцох шалтгаан болжээ.

Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг нийт ЕБС-иудын 44.0 хувь нь баримталдаггүй байна.

Тухайлбал боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд мөрдөх бусад зардлыг тооцох хувьсах зардлын дундаж нормативыг Баян-Овоо, Баянхутаг, Галшар, Дадал, Норовлин сумын ЕБС-иуд 230.5-485.2 мянган төгрөгөөр, дотуур байрны бусад зардлыг хувьсах зардлын дундаж нормативыг Бор-Өндөр, Галшар сум, Хэрлэнбаян Улаан, Хурх тосгоны ЕБС-иуд 236.2-347.8 мянган төгрөгөөр тооцсон нь бусад зардлын төсвийг хэт өсгөх шалтгаан болжээ. Харин орой, эчнээ сургалтын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрийг нэг ч ЕБС мөрдөөгүй байна.

Хууль эрх зүйн шинэчлэл, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж төсвийн төсөл бодитой бус болох магадлал байх тул цалингийн сангийн нийт хувьсах зардлын хэмжээг хэрэгцээт багшийн орон тоогоор тооцсон цалингийн сантай харьцуулах зайлшгүй шаардлагатай. Гэтэл боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай багшийн тоо, цалингийн сан, НДШ-ийг нийт ЕБС-ийн 76.0% нь тооцоогүй байгаа нь цалингийн сан дутагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

БСШУ-ны сайдын 2015 оны А/226, 2017 оны А/61 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөг үндэслэн шаардлагатай багшийг тооцоход 16 сургуульд 76 багш, үүний дотор Баянхутаг сум, Хэрлэнбаян Улаан, Хурх тосгоны ЕБС-д 8-11 багш илүү ажиллаж байна.

БСШУ-ы сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 дугаар хамтарсан тушаалд заасан бүлэг дүүргэлт Баянхутаг, Мөрөн сум, Хэрлэнбаян Улаан, Хурх, Өлзийт тосгоны ЕБС-ын бүх анги, Галшар, Дархан сумын ЕБС-ийн дунд ангийн бүлэг дүүргэлт 66.7 хувьд хүрэхгүй байгаа нь хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх боломжгүй байна.

Мөн Бор-Өндөр, Хэрлэн-1, “Тэмүүжин” цогцолбор сургуулийн зарим ангийн хүүхдийн нягтрал их, ангийн бүлгийн тоо харьцангуй олон байх тул бүтэц зохион байгуулалтад

өөрчлөлт хийх, зарим хичээлүүдийг заах мэргэжлийн багш, ялангуяа байгалийн ухааны багш нарын хөрвөх чадварыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

ЕБС-иуд санхүүжих дундаж хүүхдийн тоо, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор тогтоосон нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлаар “Үдийн цай” хөтөлбөрийн төсвийн төслийг 2017 онд 85.5 сая төгрөг, 2018 онд 90.2 сая төгрөгөөр илүү тооцсон нь хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог статистик мэдээнд суурилагүйтэй холбоотой. Мөн ЕБС-иудын өөрсдийнх нь тооцсон санхүүжих хүүхдийн тооноос “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо зөрүүтэй байгаа нь төсвийн төсөл боловсруулахдаа хариуцлагагүй хандсан байна гэж үзэхэд хүргэлээ. (АБ-7)

БСШУ-ы сайдын 2010 оны 471 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн дүрэм”-ийн 2.2-т захирал, 2.4-т сургалтын менежер, 2.5-д нийгмийн ажилтан, 2.6-д боловсролын үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зохион байгуулалтын, сургуулийн зөвлөлийн тогтоосон бүтцийн нэгжтэй байхаар заасан боловч ЕБС-ийн захиргаа, аж ахуйн бүтэц, орон тоо, цалингийн сангийн хязгаарыг жиших батлагдсан тодорхой шалгуур үзүүлэлт байхгүй байна.

Нийт ЕБС-ийн 7 нь халаалтын төвлөрсөн системд холбогдсон, 2 нь гэрээгээр халаалт авдаг, 16 нь өөрийн халаалтын системтэй байна.

ЕБС-иуд сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг 2017 онд 6904.7 сая төгрөг, 2018 онд 6849.4 сая төгрөгөөр төсөвлөжээ.

ЖИШИГ НОРМАТИВ ТОГТООГҮЙ ЗАРДАЛ (АБ-08)

(сая төгрөгөөр)

№	Арга хэмжээ	2017 онд	2018 онд	зөрүү
1	Захиргаа аж ахуйн цалин	3985.5	3773.3	-212.2
2	Гэрээт ажилчны цалин	376.6	351.3	-25.3
3	Түлш халаалт	1970.3	2092.0	121,7
4	Гэрэл цахилгаан	286.2	325.6	39,4
5	Цэвэр, бохир ус	209.3	235.5	26,2
6	Тээвэр шатахуун	76.8	71.7	-5.1
	Нийт дүн	6904.7	6849.4	

Тээвэр, шатахууны зардлыг Батноров сумын ЕБС-иас бусад сургуулиуд төсөвлөхдөө сургууль бүр өөр өөр арга хэмжээнд зарцуулахаар төсвийн төсөл боловсруулсан байгаа нь энэхүү зардлыг аймгийн хэмжээнд зохион байгуулагддаг нэгдсэн арга хэмжээнд зарцуулах талаар чиглэл өгөх нь зүйтэй юм.

ЕБС-иуд хууль эрх зүйн дагуу төрөөс нэг удаа олгох мөнгөн тэтгэмж, урамшууллыг 2017 онд 1532.1 сая төгрөг, 2018 онд 801.5 сая төгрөгөөр тооцжээ. Тэтгэмж, урамшуулал авах хүний тоо, мөнгөн дүн сум бүрт харилцан адилгүй байна. (АБ-09)

Төрийн бус өмчийн ЕБС-ийн санхүүжих хүүхдийн тоог тооцох аргачлалыг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 4.4²-т тодорхой заажээ.

² 4.4. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын төлөвлөлт, хуваарилалт, санхүүжилт, хяналтыг санхүүжих дундаж хүүхдээр тооцно. Санхүүжих дундаж хүүхдийн тоо нь тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр баталсан хүүхдийн тооноос ихгүй байна.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын хавсралт 5, санхүүжих дундаж хүүхдийг тооцох заавар³-ын дагуу тооцоход хувийн хэвшлийн “Их ирээдүй” бага сургууль 2017 онд 42.1 сая төгрөг, 2018 онд 2.2 сая төгрөгөөр илүү төсвийн төсөл боловсруулсан нь санхүүжих дундаж хүүхдийн тоог тооцох аргачлалаар тооцоогүй, хүүхдийн тоог бүлэг дүүргэлтээр тооцож, нэг суралцагчид ногдох хувьсах дундаж нормативыг баримтлаагүй байгаатай холбоотой байна. (АБ-02, 03)

В. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

“Боловсролын тухай” хуулийн 17.2⁴, БСШУ-ы сайдын 2010 оны 556 дугаар тушаалаар баталсан албан бус боловсролын “Гэгээрэл” төвийн дүрмийн 2.2⁵-т заасны дагуу албан бус боловсролыг бие даасан НТБ-ын төв, сумдын ЕБС-ийг түшиглэн зохион байгуулж байна. БСШУС-ын яамны харьяа “Насан туршийн боловсролын Үндэсний төв”-ийн бодлого, шинэчлэлийн дагуу “Гэгээрэл” төвийг 2015 онд “Насан туршийн боловсролын төв” болгон өөрчилж, сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгожээ.

НТБ олгох сургалтын төсвийг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрээр тооцоход 2017 онд 994.9 сая төгрөг, 2018 онд 789.5 сая төгрөгөөр илүү тооцсон нь санхүүжих дундаж хүүхдийн тоог аргачлалын дагуу тооцоогүй, хувьсах зардлын дундаж нормативыг баримтлаагүйтэй холбоотой байна. (АБ-06)

НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦОХ ЗАРДАЛ

(сая төгрөгөөр)

№	Арга хэмжээ	2017 онд			2018 онд			СДХ	ХЗДН
		ЕБС	АУДИТ	зөрүү	ЕБС	АУДИТ	зөрүү		
1	ЕБС-иуд-Дүйцсэн хөтөлбөр (хавсралт 11)	975.7	58.8	916.9	761.0	47.6	713.4	✓	✓
2	НТБ-ын төв (хавсралт 12)	137.4	59.4	78.0	141.7	65.6	76.1	✓	✓
	Нийт дүн	1113.1	118.2	994,9	902.7	113.2	789.5		

НТБ-ын сургалтад хамрагсдын судалгаа хангалтгүй, нийт ЕБС-иудын 75.0 хувь нь багшийн цалингийн сангийн, 70.0 хувь нь бусад зардлын дундаж нормативыг, 80.0 хувь нь итгэлцүүрийг баримтлаагүй, НТБ-ын төв нь сургалтад хамрагсдын тоог сумдын ЕБС-ийн тоотой давхардуулан тооцсоноос гадна Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолыг баримтлаагүй байна.

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ.

Аймгийн НТБ-ын төв 10 орон тоотой ба аймгийн хэмжээнд албан бус боловсролд хамрагдах иргэдийн судалгаа, бүртгэл, статистик мэдээ, мэдээллийг хариуцаж, ЕБС-иудыг сургалтын арга зүй, чиглэлээр ханган ажилладаг байна.

НТБ-ын төвийн захиргаа аж ахуйн орон тоо, түүний цалингийн сангийн төсвийн төслийг боловсруулахдаа сумдын НТБ-ын багш нарыг хамааруулан боловсруулснаас шалгах боломжгүй байна. (АБ-06)

НТБ-ын төв нь өөрийн эзэмшлийн бус байранд үйл ажиллагаа явуулдаг ба байр ашиглалттай холбоотой зардлыг 2017 онд 5.7 сая төгрөг, 2018 онд 80.2 сая төгрөгөөр,

³ “Байгууллагын төсөв санхүүгийн төлөвлөлт, удирдлагын арга зүй” 2015 номын 133-р хуудас.

⁴ 17.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт албан бус сургалтыг зохион байгуулах, бие даан суралцагчид туслах үүрэг бүхий албан бус боловсролын төвийг бие даасан хэлбэрээр, эсхүл сургалтын байгууллагыг түшиглүүлэн ажиллуулна.

⁵ 2.2 төвийг 6000 доош хүн амтай суманд сургууль түшиглэсэн, 6000 дээш хүнтэй сумдад сумын ЗДТГ бие даасан, Улаан баатар хотод дүүргүүдийн ЗДТГ-ын дэргэд бие даасан Гэгээрэл төв гэсэн статустай байгуулна.

сумын ЕБС-иудад сургалт, арга зүйн зөвлөгөө өгч, шалган туслах ажилд зориулан тээвэр шатахууны зардлыг 2017, 2018 ондуудад 2.1 сая төгрөгөөр тус тус төсөвлөжээ.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 22/09/081/23 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэхээр НТБ-ын сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц байртай болох хүсэлтийг аймгийн ЗДТГ, БСУГ-т 2017 оны 30, 31 тоот албан бичгээр хүргүүлжээ. Эрх бүхий албан тушаалтны амаар өгсөн чиглэлийн дагуу МСҮТ-ийн ашиглагдаагүй (хуучин) барилгын 6600 м² талбайд сургалт зохион байгуулахаар төлөвлөж, байр ашиглалттай холбоотой зардлыг 2018 онд 74.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөжээ. (АБ-08)

1.2 АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙГ ХЯНАХДАА САНХҮҮЖИХ ДУНДАЖ ХҮҮХДИЙН ТООНД СУУРИЛААГҮЙ БАЙНА.

А. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХЯНАСАН ТАЛААР

Хэнтий аймгийн хэмжээнд СӨБ-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа 34 байгууллагаас төрийн өмчийн 32 байгууллага төсвийн төсөл боловсруулж аймгийн БСУГ-т ирүүлсэн бол хувийн хэвшлийн 2 цэцэрлэг төсвийн төсөл боловсруулж ирүүлээгүй байна.

Төсвийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг 3 бүлэг 12 үзүүлэлтээр дүгнэж үзэхэд Батноров, Энхжин, Дархан, Хэрлэн 6, Цэнхэрмандал сумдын цэцэрлэгүүд тус тус 9 үзүүлэлтийг хангасан буюу хамгийн сайн боловсруулсан, Баянмөнх, Баянхутаг сумдын цэцэрлэгүүд хангалтгүй буюу 5 үзүүлэлтийг хангасан байна. СӨБ-ын байгууллагууд төсвийн төслийн баримт бичигт төсвийн танилцуулга, хууль эрх зүйн шийдвэр тогтоолын хуулбар, төсвийн төслийн үнэн зөвийг нотлох баримт бичгүүдийг нийтлэг бүрдүүлээгүй, төсвийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг хангаагүй төсөв боловсруулж байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Мөн 2017 онд СӨБ-ын байгууллагууд өдрийн бүлэгт 5961 хүүхэд суралцаж 8,7 тэрбум төгрөгийн төсвийн төсөл ирүүлснийг аймгийн БСУГ нь 6247 хүүхэд, 8,8 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн, 19 цэцэрлэгийн нүүдлийн бүлэгт 1149 хүүхэд, явуулын бүлэгт 115 хүүхэд, ээлжийн бүлэгт 120 хүүхэд хамруулахаар нийт 97,8 сая төгрөгийн санал ирснийг 20 цэцэрлэгт нүүдлийн бүлэгт 1175 хүүхэд, явуулын бүлэгт 16 хүүхэд, ээлжийн бүлэгт 65 хүүхэд хамруулахаар нийт 83,5 сая төгрөг болгон бууруулан суурь үзүүлэлтийг тухайн жилийн статистик тоонд үндэслэн хянаж нэгтгэсэн нь суурь үзүүлэлт тооцох аргачлалыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

“Төсвийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана”, 22.2-д “төсвийг төсвийн шатлалаар, төсвийн захирагчаар, эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр, санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилах”-аар заасан боловч СӨБ-ын байгууллагууд төсвийн төсөл боловсруулахдаа БШУ-ны сайдын 2010 оны 256 дугаар тушаалын дагуу тооцох томъёоллыг багтаасан загвар маягтыг ашиглаж байна. Энэ загвар маягтад зориулалт арга хэмжээгээр нь төлөвлөх тооцоолол хийгдээгүй тул төлөвлөлтийг зөвхөн эдийн засгийн ангиллын дагуу хийж байгаа нь “Төсвийн тухай” хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХЯНАСАН ТАЛААР

Аймгийн БСУГ нь ЕБС-иудаас ирүүлсэн төсвийн төслийг 2017 онд 1404.6 сая төгрөг, 2018 онд 977.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2017 онд 19889.3 сая төгрөг, 2018 онд 18822.4 сая төгрөгөөр хянан нэгтгэж, БСШУС-ын яаманд хүргүүлжээ.

Аймгийн БСУГ нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар төлөвлөх зардлыг хянахдаа ЕБС-иудын төлөвлөснийг 2017 онд 1189.7 сая төгрөг, 2018 онд 962.9 сая төгрөгөөр бууруулсан ч 2017 онд 356.4 сая төгрөг, 2018 онд 558.7 сая төгрөгөөр илүү байгаа

нь тухайн жилд санхүүжих дундаж хүүхдийн тоог статистик мэдээнд суурилан тооцоогүйгээс шалтгаалсан байна.

**НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ
НОРМАТИВ, ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦОХ ЗАРДАЛ**

№	Арга хэмжээ	2017 онд			2018 онд		
		БСУГ	ЕБС-иас	АУДИТ-аас	БСУГ	ЕБС-иас	АУДИТ-аас
1	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ (АБ-2, 3)	6044.1	-851.2	195.7	6124.8	-652.8	301.8
2	Дотуур байрны зардал (АБ-04)	397.3	-286.4	-7.5	395.5	-267.3	19.4
3	Дотуур байрны хоолны зардал (АБ-04)	901.4	-37.0	197.9	901.4	-33.0	256.6
4	Орой, эчнээ сургалтын зардал (АБ-05)	26.9	-15.1	-29.7	26.9	-9.8	-19.1
	Нийт дүн	7369.7	-1189,7	356,4	7448,6	-962,9	558,7

Аймгийн БСУГ санхүүжих хүүхдийг ЕБС-иудын ирүүлсэн тооноос 2017 онд 27, 2018 онд 264-өөр нэмэгдүүлэн 2017 онд 14899, 2018 онд 15275 хүүхдээр тооцсон нь үндэслэлгүй байна. Энэ нь Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 5.2.2^б-т заасныг зөрчсөн байна.

Аймгийн хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд 13736, 2016-2017 оны хичээлийн жилд 13818, 2017-2018 онд 14540 сурагч суралцаж байжээ.

Дотуур байрны зардлыг хянахдаа өмнөх жилүүдийн хүүхдийн тоонд суурилагүй, ажилчдын цалингийн санг хувьсах зардлын дундаж нормативаар тооцоогүй байна.

Аймгийн БСУГ “Үдийн цай” хөтөлбөрийн төсвийг 2017 онд 42.8 сая төгрөг, 2018 онд 55.6 сая төгрөгөөр илүү хянасан нь хүүхдийн тоог статистик мэдээнд суурилан тооцоогүйгээс шалтгаалжээ. (АБ-07)

Орой, эчнээ сургалтаар боловсрол олгох арга хэмжээний төсвийг хянахдаа суралцагчийн судалгаа хангалтгүй, хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрийг баримтлаагүй байна.

Аймгийн БСУГ нь ЕБС-иудын боловсруулсан сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээний төсвийн төслийг хянахдаа ажиллагсдын цалингийн санг 2017 онд 431.2 сая төгрөг, 2018 онд 401.29 сая төгрөгөөр, гэрээт ажилчны цалингийн санг 2017 онд 84.8 сая төгрөг, 2018 онд 103.4 сая төгрөгөөр бууруулжээ.

Харин тогтмол зардлын төсвийг өмнөх оны батлагдсан төсвөөс 2017 онд 1417.4 сая төгрөг, 2018 онд 817.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь сургуулийн барилгын өргөтгөл, уурын зуухны шинэчлэл болон зах зээлийн үнийн өсөлттэй холбоотой байна. (АБ-08)

Мөн тухайн оны төсвийн төсөл боловсруулах чиглэлийн дагуу ЕБС-иудад үйлчилгээ үзүүлэгч байгууллага, интернетийн холболтын төрөл, хурд, сарын төлбөрийн хэмжээнд үндэслэн интернетийн холболтын зардлыг 2017 онд 13.4 сая төгрөг, 2018 онд 13.4 сая төгрөгөөр тооцож нэмж тооцсон байна.

^б 5.2.2. харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;

Аймгийн БСУГ хууль, эрх зүйн дагуу төрөөс олгох тэтгэмж, урамшууллыг 2017 онд 16.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2018 онд 124.3 сая төгрөгөөр бууруулан хянажээ. Энэ нь ЕБС-иуд тэтгэмж, урамшуулал авах хүний ажилласан жилийг алдаатай тооцох, хуулийн үндэслэлийг буруу сонгож авснаас шалтгаалжээ. (АБ-09)

Улирлын ажлын үр дүнгээр олгох урамшууллын зардлын төсвийг ЕБС-иуд боловсруулаагүй ч аймгийн БСУГ Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолын дагуу 2017 онд 1023.0 сая төгрөг, 2018 онд 780.7 сая төгрөгөөр тооцож хянажээ. Багш, бусад албан хаагчдад олгох урамшууллын хувь хэмжээг 2018 онд бууруулжээ. Энэ нь “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам”-ын 2.3⁷ заалттай нийцэж байна. (АБ-10)

Төрийн бус өмчийн “Их ирээдүй” бага сургуульд төсвөөс олгох дэмжлэгийг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын хавсралт 5-ын дагуу тооцож хянажээ. Мөн тус бага сургуулийн боловсруулсан “Үдийн цай” хөтөлбөрийн төсвийг 2017 онд 4.3 сая төгрөг, 2018 онд 3.5 сая төгрөгөөр бууруулан хянасныг журмын дагуу тооцоолоход 2017 0.8 сая төгрөг, 2018 онд 3.4 сая төгрөгөөр дутуу байгаа нь санхүүжих дундаж хүүхдийн тоог статистик мэдээнд суурилж тооцоогүйгээс шалтгаалжээ. (АБ-02, 03)

В. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХЯНАСАН ТАЛААР

Аймгийн БСУГ нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар НТБ олгох сургалтын зардлыг хянахдаа тодорхой хэмжээгээр бууруулсан ч 2017 онд 146.8 сая төгрөг, 2018 онд 151.9 сая төгрөгөөр илүү байгаа нь албан бус сургалтад хамрагсдын судалгаа муутай, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрээр зардлыг тооцдоггүйтэй холбоотой байна.

НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦОХ ЗАРДАЛ

№	Арга хэмжээ	2017 онд			2018 онд		
		БСУГ	ЕБС-иас	АУДИТ-аас	БСУГ	ЕБС-иас	АУДИТ-аас
1	ЕБС-иуд НТБ-Дүйцсэн хөтөлбөр	110.7	-865.0	51.9	110.7	-650.3	63.1
2	НТБ-ын төв	154.4	17.0	94.9	154.4	12.6	88.8
	Нийт дүн	265,1	-848,0	146,8	265,1	-637,7	151,9

Бичиг үсгийн боловсрол олгох сургалтад хамрагдах иргэний тоог 2017 онд 228, 2018 онд 211-ээр нэмэгдүүлж, багшийн цалингийн сан, бусад зардалд 2017, 2018 ондуудад төсөв хянаагүй, амьдрах ухаанд сургах сургалтын төсвийг ЕБС-иуд тооцсон ч аймгийн БСУГ хянаж, зардал төсөвлөөгүй байна. (АБ-06)

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ.

Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээний цалингийн зардлыг 2017 онд 227.6 сая төгрөг, 2018 онд 245.7 сая төгрөгөөр бууруулсан нь сумдын ЕБС-иудад ажиллаж байгаа НТБ олгох багш нарыг НТБ-ын төвийн орон тооноос хасаж тооцжээ. Харин байр ашиглалттай холбоотой зардлыг төрийн өмчийн ЕБС-ийн байр ашигладаг тул хянаагүй байна. (АБ-06)

⁷ 2.3. Төрийн өмчийн сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчийн ажлыг үнэлж, дүгнэх журамд заасан шалгуурын биелэлт 70-аас доош хувьтай үнэлэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчид үр дүнгийн урамшил олгохгүй.

БҮЛЭГ 2: ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН САНХҮҮЖИЛТ ҮНДЭСЛЭЛ МУУТАЙ ХУВААРИЛАГДСАН БАЙНА.

2.1 САНГИЙН САЙДЫН БАТАЛСАН ТӨСВИЙН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ ХУВААРИЛСАН БАЙНА.

А. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТЫН ТАЛААР

СӨБ-ын байгууллагуудын төсвийг 2017 онд Сангийн яамнаас 8547,6 сая төгрөг, 586 орон тоотой, 2018 онд 8870,8 сая төгрөг, 586 орон тоотой байхаар тус тус хянаж ирүүлснийг аймгийн БСУГ дараах зориулалтаар хуваарилсан байна.

Зориулалт арга хэмжээгээр хуваарилсан төсөв 2017-2018 он /сая төгрөг/

№	Зориулалт, арга хэмжээ	2017 он	2018 он
1	Боловсролын стандарт төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	7010,7	7028,0
2	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	1253,9	1360,8
3	Хүүхэд хөгжил хөтөлбөр	163,4	162,4
4	Төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн урамшуулал	36,0	
5	Биеийн тамир уралдаан тэмцээн	36,0	7,4
6	Хувийн хэвшилд олгох татаас	47,7	111,3
7	Сахилга, хариуцлага шагнал урамшуулал		201,0
	НИЙТ	8547,6	8870,8
1	Орон тоо	687	692

Төсвийн төслийг боловсруулахдаа зориулалт арга хэмжээгээр төлөвлөөгүй тул нэгж байгууллагуудаас ирсэн саналтай харьцуулж хэрхэн хуваарилалт хийснийг дүгнэх боломжгүй байна.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаар 586 байхад 2017 онд 101, 2018 онд 106 орон тоогоор хэтрүүлэн хуваарилалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах”, 66 дугаар зүйлийн 66.1.7 “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Хүүхэд хөгжлийн хөтөлбөрт 163,4 сая төгрөг батлагдсан ч төсвийн төсөлд огт тусгагдаагүй байна. Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн төсвийг хэрхэн хуваарилах, ямар зориулалтаар зарцуулах талаар нэгдсэн чиглэл зөвлөмж байхгүй байгаагаас шалтгаалан БСУГ ирсэн төсвийг нэгжүүдэд ямар нэгэн судалгаа, тооцоололгүй, харилцан адилгүй хуваарилсан байна. Үүнд: Хэрлэн 1 дүгээр цэцэрлэгт 30,0 сая төгрөг, Хэрлэн 3 дугаар цэцэрлэгт 25,0 сая төгрөг, Хэрлэн 8 дугаар цэцэрлэг 23,0 сая төгрөг, бусад цэцэрлэгүүдэд дунджаар 2,0-5,0 сая төгрөг.

Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн төсөв 2018 онд 162,3 сая төгрөгөөр батлагдаж ирснийг нэгж байгууллагуудад дунджаар 2,0-8,0 сая төгрөгийн хооронд хуваарилснаас үзэхэд хуваарилалтыг тэгш хийх боломжтой байна. Гэхдээ тухайн хөтөлбөрийн зорилго, чиглэлтэй нийцэж байна гэж үзэх үндэслэлгүй юм.

Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн БСУГ-ын нэгтгэсэн төсвийн төслийг БСШУС-ын яам 2017 онд 2170.5 сая төгрөгөөр бууруулж, 2018 онд 102.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2017 онд 17141.3 сая төгрөг, 2018 онд 18367.0 сая төгрөгөөр баталжээ.

УИХ-ын 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан Монгол улсын 2017 оны төсөвт Хэнтий аймгийн ЕБС-ийн нийт төсвийг 17141.3 сая төгрөг, 1620 ажиллагсад, 14716 суралцагч байхаар баталсан байна.

Аймгийн БСУГ тусгай зориулалтын шилжүүлгээс 25 ЕБС-д 17001.1 сая төгрөг, төрийн бус өмчийн ЕБС-д олгох татааст 30.6 сая төгрөг, НТБТ-д 109.6 сая төгрөгийг хуваарилан аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн хуралдаанаар Хэнтий аймгийн ЕБС-иудын 2017 оны төсвийг нийт 17141.3 сая төгрөгөөр батлуулжээ. (АБ-12)

Аймгийн БСУГ-ын хуваарилсан төсвийг хянасан төсөвтэй нь харьцуулахад ЕБС-ийн төсвийн эзлэх хувьд өөрчлөлт оржээ.

Баян-Адрага, Баянмөнх, Баянхутаг, Биндэр, Бор-Өндөр, Галшар, Дархан, Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян Улаан, Өлзийт тосгоны ЕБС-иудын эзлэх хувь 0.1-0.3%-иар, “Их ирээдүй” бага сургуулийн 0.2%, НТБТ-ийн нийт төсөвт эзлэх хувь 1.9%-иар тус тус буурсан байна. Харин Батноров, Батширээт, Дадал, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр сум, Бэрх, Хурх тосгон болон Хэрлэн-1, “Тэмүүжин” цогцолбор сургуулийн эзлэх хувь 1.9-12.2%-иар өссөн байна.

УИХ-ын 2017 оны 11-р сарын 14-ний өдрийн хуралдаанаар баталсан Монгол улсын 2018 оны төсөвт Хэнтий аймгийн ЕБС-ийн нийт төсвийг 18367.0 сая төгрөг, 1617 ажиллагсад, 15227 суралцагч байхаар баталсан байна.

Аймгийн БСУГ тусгай зориулалтын шилжүүлгээс 25 ЕБС-д 18140.6 сая төгрөг, төрийн бус өмчийн ЕБС-д олгох татааст 72.2 сая төгрөг, НТБТ-д 154.2 сая төгрөгийг хуваарилан аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн хуралдаанаар Хэнтий аймгийн ЕБС-иудын 2018 оны төсвийг нийт 18367.0 сая төгрөгөөр батлуулжээ. (АБ-13)

Аймгийн БСУГ-ын хуваарилсан төсвийг хянасан төсөвтэй нь харьцуулахад ЕБС-ийн төсвийн эзлэх хувьд өөрчлөлт оржээ.

Батноров, Баян-Адрага, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар, Дархан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сум, Бэрх, Хэрлэнбаян Улаан, Өлзийт тосгоны ЕБС-иуд болон Хэрлэн-4 сургуулийн нийт төсөвт эзлэх хувь 0.1-0.4%-иар, НТБ-ын төвийн эзлэх хувь 1.8%-иар тус тус буурсан байна. Харин Дадал сум, Хурх тосгоны ЕБС болон Хэрлэн-1, “Хан Хэнтий”, “Тэмүүжин” цогцолбор сургуулийн эзлэх хувь 0.1-2.2%-иар өссөн байна

Сангийн яамнаас 2017, 2018 оны төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар ирүүлснийг аймгийн БСУГ байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зэрэг суурь үзүүлэлтээр хянагдаж болох зардлуудыг хуваарилахдаа “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.1.7⁸-д заасан зөвшөөрөл аваагүй байна.

2.2 ТӨСӨВТ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХДЭЭ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХИЙЖ, БОДИТ ТООЦООЛОЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА.

Хэнтий аймгийн боловсролын салбарын нэгж байгууллагуудын 2017 оны төсөвт “Төсвийн тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д заасны дагуу 2 удаа төсвийн тодотгол хийгдсэн байна.


А. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

2017 оны 5 сард хийсэн төсвийн тодотголоор Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр сумдын цэцэрлэгүүдэд хоол, түлш халаалт, Баянхутаг сумын цэцэрлэгт хүүхэд хөгжлийн хөтөлбөрт, Хурх тосгоны цэцэрлэгээс 22,7 сая төгрөгийн тэтгэмж хасагдаж, Жаргалтхаан

⁸ 4.1.7.Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авсан байх.

суманд нэмэгдсэн зэрэг голлох өөрчлөлтүүд орсон байна. “Хүүхэд хөгжил” хөтөлбөрийн зардлыг Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн төсвөөс 23,0 сая төгрөгийг хасаж Баянхутаг сумын цэцэрлэгт олгосон нь тодорхой үндэслэлгүй байна.

2017 оны 11 сард хийсэн төсвийн тодотголоор төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн 300,0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой голлох өөрчлөлтүүд оржээ.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2017 оны төсөвт зохицуулалт хийхдээ Батширээт, Галшар, Норовлин, Өмнөдэлгэр сум, Хурх тосгоны цэцэрлэгийн төсвийг 0.1-14.7 хувиар бууруулж, Баянхутаг, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумын цэцэрлэгийн төсвийг харьцангуй өндөр буюу 9.5-26.5 хувиар өсгөсөн байна.


Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Хэнтий аймгийн ЕБС-ийн 2017 оны нийт төсвийг УИХ-ын 2017 оны 4-р сарын 14-ний өдрийн хуралдаанаар 17124,7 сая төгрөг, УИХ-ын 2017 оны 11-р сарын 14-ны өдрийн хуралдаанаар 17610.7 сая төгрөг болгон тус тус тодотгосон байна.

УИХ-аар батлагдсан тусгай зориулалтын шилжүүлэг дээр дээр “Төсвийн тухай” хуулийн 61.4⁹-д заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 136 дугаар албан бичгээр нэмэгдсэн 463.4 сая төгрөг, ЕБС-иудын өөрийн орлого 15.0 сая төгрөгийг нэмж Хэнтий аймгийн ЕБС-иудын тодотгосон төсвийг 18089.2 сая төгрөгөөр тооцож аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн хуралдаанаар батлуулсан байна.

⁹ 61.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална.

Аймгийн БСУГ тодотгосон төсвөөс 25 ЕБС-д 17899.7 сая төгрөг, төрийн бус өмчийн ЕБС-д олгох татааст 71.4 сая төгрөг, НТБТ-д 118.1 сая төгрөгийг хуваарилжээ. (АБ-12)



Бага, дунд боловсролын байгууллагын 2017 оны төсөвт зохицуулалт хийхдээ Батноров, Батширээт сум, Өлзийт тосгоны сургуулийн төсвийг 0.1-2.1 хувиар бууруулж, Баянмөнх, Бор-Өндөр сум, Хэрлэн 1 ба 4, “Хан Хэнтий”, “Тэмүүжин” цогцолбор сургуулийн төсвийг харьцангуй өндөр буюу 7.0-10.8 хувиар өсгөсөн байна. Харин төрийн бус өмчийн ЕБС-ийн төсөв 132.9%, НТБТ-ийн төсөв 7.8%-иар өсжээ.

Төсвийн авлага, өр үүсгэхгүй байх чиглэл бүхий төсөвт зохицуулалт хийх зөвшөөрлийг БСШУС-ын сайдын 2017 оны 11 сарын 27-ны өдрийн 1а/11253 дугаар албан бичгээр ирүүлсний дагуу ТШЗ-ийн төсөв хооронд болон зардлын эдийн засгийн ангилалд зохицуулалт хийгджээ. Харин ТШЗ-ийн төсөвт зохицуулалт хийх санал, хүсэлт, судалгаа хангалтгүй байна.

БҮЛЭГ 3: ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫН САНХҮҮЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 ЦЭЦЭРЛЭГИЙН БОЛОН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ЗАРДАЛ, “ҮДИЙН ЦАЙ” ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭМНЭХ БОЛОМЖ БАЙНА.

А. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

СӨБ-ын байгууллагууд 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 8690,4 сая төгрөгийн санхүүжилт авч 8666,5 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 23,8 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Дээрх үлдэгдэлд цалингийн сан нийт дүнгээр 7,3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 5,3 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 1,0 сая төгрөг, нормативт зардал 1,8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 5,0 сая төгрөг багтсан байна.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас СӨБ-ын нийт 32 байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж 30 байгууллагад зөрчилгүй санал дүгнэлт, Мөрөн сумын цэцэрлэг, Өлзийт тосгоны цэцэрлэгт хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг ангилж үзвэл. /сая төгрөг/

№	Цэцэрлэгийн нэрс	Зөрчлийн утга	Зөрчлийн мөнгөн дүн /сая төгрөг/
1	Жаргалтхаан, Өлзийт, Хэрлэн-5, Хэрлэн-7	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нормыг хэтрүүлэн зарцуулсан	2,3
2	Өлзийт, Галшар	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	6,8
3	Хэрлэн-3, Хэрлэн-4, Хэрлэн-5, Бэрх	Биетээр хүлээж аваагүй мэдрэгчтэй крантыг орлогоор тусгасан	9,1
4	Норовлин, Цэнхэрмандал, Биндэр	Цалингийн зардлаас НДШ төлсөн	0,6
5	Биндэр	Худаг гаргуулах гэрээ хийж мөнгийг шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, зардалд хаасан	5,1
	ДҮН		23,9

СӨБ-ын байгууллагууд хоолны зарцуулалтад тавих хяналт сул, төсвийг зориулалт бусаар зарцуулсан нэр бүхий цэцэрлэгүүдийн биетээр хүлээж аваагүй мэдрэгчтэй крантын зөрчлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн тайланд нь авлагаар тусгуулж авлагыг барагдуулж ажиллах зөвлөмж өгсөн боловч тодорхой ажил зохион байгуулаагүй нь төсвийн сахилга бат муу, гэрээ хэлцлийг чанартай хийдэггүй, гүйцэтгэлийг үнэлдэггүй зэрэгтэй холбоотой байна.

Б. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

Төсвийн гүйцэтгэлийг байгууллагын хэв шинжээр ангилбал ердийн сургалттай ЕБС-иуд 17876.7 сая төгрөг, төрийн бус өмчийн ЕБС-ийн татааст 71.4 сая төгрөг, НТБ-ын төв 118.1 сая төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 22,9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. (АБ-12)

Аймгийн БСУГ дотуур байранд амьдрах хүүхдийн тоог 2017 онд 21.4 хувиар, “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог 7.8 хувиар илүү хянасныг тооцвол төсвийн гүйцэтгэлээс нийт 175.9 сая төгрөг хэмнэгдэх боломж байсан боловч ТЕЗ-ийн өгсөн зөвшөөрлийн дагуу зохицуулалт хийгдэж, 1.9 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэнийг төвлөрүүлжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46.0 сая төгрөгийн зөрчил илэрсний дотор хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа, үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд зөвшөөрөгдөх материаллаг байдлаас их байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай. (АБ-12)

3.2 НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВТ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР САР БҮР ХҮҮХЭД ӨДРӨӨР ХЯНААГҮЙ БАЙНА.

Засгийн газрын 2016 оны 242-р тогтоолоор батлагдсан “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВААР САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ”-ын 3.12, 4.5, 5.3-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, өмчийн хэлбэр үл харгалзан хүүхдийн цэцэрлэгийн хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймгийн БСУГ сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгож байх үүрэгтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2017 онд боловсролын салбар нэгжүүдийн 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн нь аудитын хамрах хүрээнд хамааралгүй байна.

Аймгийн БСУГ өмчийн хэлбэр үл харгалзан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагуудын хувьсах зардлын дундаж нормативт зардлын санхүүжилтийг сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгож байх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийг хянах нэг боломж бол “Шилэн дансны тухай” хуулийн 8.4¹⁰-т заасан хяналт юм.

Шилэн дансанд батлагдсан төсвийг 2017 онд 14 ЕБС зөрүүтэй мэдээлж, Мөрөн, Өлзийт, “Их ирээдүй” ЕБС мэдээлээгүй, 2018 онд Дадал, Хэрлэн-4 ЕБС зөрүүтэй мэдээлсэн, төсвийн гүйцэтгэлийг 2017 онд 18 ЕБС зөрүүтэй мэдээлж, Мөрөн ЕБС мэдээлээгүй байгаа нь аймгийн БСУГ хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлээгүй байгаатай холбоотой.

¹⁰ 8.4. Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- 1) Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагуудыг төсвийн төсөл боловсруулах удирдлага, арга зүйгээр хангах талаар аймгийн БСУГ хангалтгүй ажилласан байна.
- 2) Анхан шатны нэгжүүд төсвийн төсөл боловсруулахдаа санхүүжих дундаж хүүхдийг тооцох аргачлал, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрийг баримтлаагүй байна.
- 3) Аймгийн БСУГ төсвийн төслийг нэгтгэхдээ санхүүжих дундаж хүүхдийн тоо, тооцооллын үнэн зөв эсэхэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 4) Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлгүүдэд өөрчлөлт оруулж төсвийг хуваарилсан байна.
- 5) Төсвийн зохицуулалт хийхдээ санал, хүсэлт, судалгаа шинжилгээ, бодит тоо баримтад үндэслэдэггүй, энэ талаар нотлох баримт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
- 6) Хувьсах зардлын дундаж нормативт зардлын зарцуулалтад сар бүр хүүхэд өдрөөр тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБАД**

1. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжих боломжгүй ЕБС-иудын хэв шинжийг оновчтой болгох талаар судалгаа, шинжилгээ хийж ажиллах
2. Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, тус салбарын төсвийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээр хянуулж, баталгаажуулсны дараа аймгийн ИТХ-аар батлуулах


АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА С.МӨНХЦЭЦЭГТ

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагуудыг төсвийн төсөл боловсруулах удирдлага, арга зүйгээр хангаж, төслийг санхүүжих дундаж хүүхдийг тооцох аргачлал, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрийг баримтлан хүлээн авч, нэгтгэж байх
2. Хувьсах зардлын дундаж нормативаар хуваарилагдах зардлуудын эзлэх хувийг аймгийн дунджаар жил бүр тогтоож төсвийн төсөл боловсруулах, хуваарилахдаа баримтлах
3. Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн зардлын зориулалт, зарцуулалт, хянах журам боловсруулан батлуулж, тодорхой тооцоо судалгаанд үндэслэн хуваарилж байх
4. Төсвийг хуваарилах, төсвийн зохицуулалт хийхдээ журамд заасан шаардлага хангасан саналд үндэслэн, зохицуулалт хийх хязгаарыг баримталж ажиллах
5. Төсвийн мэргэжилтний ажлын байрны үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой болгож, ажилдаа хайнга хандаж байгаа мэргэжилтэнд ажлын хариуцлага тооцож, боловсролын салбарын төсвийн төслийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхийн өмнө заавал аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээр хянуулж, баталгаажуулах
6. Өмчийн хэлбэрийг үл харгалзан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хувьсах зардлын дундаж нормативаар сар, улирал тутам тавих хяналтыг сайжруулах.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр гаргаж тайлан хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор, хэрэгжилтийн тайланг 2018 оны 12-р сарын 10-ны дотор албан бичгээр Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

2АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ


ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ БА ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал	Тайлбар
<p>№</p>  <p style="text-align: center;">ХЭНТИЙ АЙМАГ БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР</p> <p style="text-align: center;">23117 Чингис хот, Хэрлэн сум, Утас: 70-56-36-40</p> <p style="text-align: center;">2018.07.03 № 219 танай _____-ы № _____-т</p> <p style="text-align: center;">Г Санал хүргүүлэх тухай Г</p>	
<p>Хэнтий аймаг дахь төрийн аудитын газраас боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн дагуу дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.1. Нэгж байгууллагуудын ирүүлсэн төсвийн төслийн саналд Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолыг баримтлаагүй, буруу тооцсон зөрчлүүд илэрсэн байна. Орон нутгийн нэгж байгууллагууд төсвийн төслийг хийж гүйцэтгэхдээ 2016, 2017 онд тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг буруу тооцож байсан тул 2018 оны төсвийн төсөлд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгогдох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг хууль тогтоомжийн дагуу сайн хянаж нэгтгэсний үр дүнд 2018 онд зөрчил илрээгүй байна. Цаашид нэгж байгууллагуудын төсвийн төслийн саналыг эдийн засгийн ангилал тус бүрээр нь хянаж нэгтгэн ажиллах болно.</p>	<p>1.1 Энэ талаар тайлангийн 1.1 хэсэгт тусгасан, ажлын баримт 02, 09-өөс дэлгэрэнгүй харж болно.</p>
<p>1.2. Орон нутгийн нэгж байгууллагууд дараа оны төсвийн төслийн санхүүжих хүүхдийн тоог тооцохдоо тухайн орон нутгийн жилийн эцсийн хүн амын статистик тоон мэдээлэл, өмнөх оны хүүхдийн тооны хэлбэлзэлд үндэслэн төлөвлөдөг байна. Боловсрол, соёл, урлагийн газар санхүүжих хүүхдийн тоог төлөвлөхдөө нэгж байгууллагын төсөөллөөр явуулдаг. Харин төсвийг хуваарилах болон төсвийн тодотгол хийхэд санхүүжих хүүхдийн тоог боловсролын байгууллагын мэдээллийн баазад орсон хүүхдийн тоогоор санхүүждэг тул өмнөх оны төсвийн төсөөллийн тооноос зөрүүтэй байдаг. Мөн санхүүжих хүүхдийн тоо нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хэлбэлзэл тогтмол гарч байдаг.</p>	<p>1.2 “Байгууллагын төсөв, санхүүгийн төлөвлөлт, удирдлагын арга зүй” 2015 номын 133 хуудсанд тодорхой зааж өгсөн. СДХ-ийн тооцоо өмнөх хичээлийн жилүүдийн статистик мэдээнд суурилах тул хүлээн авах боломжгүй.</p>
<p>2.1. Аймгийн Засаг даргын БСШУСЯамны сайдтай байгуулсан 2017 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 2017/18 дугаартай үр дүнгийн гэрээ, 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 2018/18 дугаартай үр дүнгийн гэрээнд тус тус боловсролын салбарын төсвийг эдийн засгийн ангиллаар нь бус нийт дүнгээр нь тусгасан байдаг. Сангийн сайдын баталсан төсөв эдийн засгийн ангиллаараа ирдэг боловч орон нутгийн онцлог хэрэгцээнд болон нэгж байгууллагын саналд тулгуурлан хуваарилж аймгийн ИТХ-аар батлуулдаг. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын “Хүүхэд хөгжил хөтөлбөр” зардлыг нэгж байгууллагуудын саналыг авч нэгтгэн хуваарилаж байгаа бөгөөд зарцуулалтыг Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн 1/1794 тоот захирамжийн дагуу цэгцэлж өгсөн.</p>	<p>2.1. “Боловсролын тухай” хууль 40-р зүйл, “Төсвийн тухай” хууль 22.2¹¹, 22.6.6¹², 22.6.8¹³ заалтыг хэрэгжүүлэх.</p>
<p>2.2. Төсөвт зохицуулалт хийхдээ буюу төсвийн тодотгол хийхэд тухайн байгууллагын төсвийн шууд захирагч нарын албан тоот хүсэлтийн дагуу хуулийн хүрээнд хэмнэгдсэн зардлаас шаардлагатай байгаа зардалд шилжүүлэн төсөвт зохицуулалт хийж байна. Хувийн хэвшлийн байгууллагууд</p>	<p>2.2. Сангийн сайдын 2013 оны 73-р тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам” 3.1 нөхцөл</p>

¹¹ 22.2.Төсвийг дор дурдсаны дагуу ангилна: 22.2.1.төсвийн шатлалаар; 22.2.2.төсвийн захирагчаар; 22.2.3.эдийн засгийн ангиллаар; 22.2.4.хөтөлбөрөөр; 22.2.5.арга хэмжээгээр; 22.2.6.санхүүжүүлэх эх үүсвэрээр.

¹² 22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

¹³ 22.6.8.төсвийн гүйцэтгэлийн явцын хяналтыг энэ хуулийн 22.2-т заасан ангиллаар хийх бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дотор томсгосон ангиллаар хяналтын түвшинг тогтоож болно.

<p>болох Их-ирээдүй бага сургууль, Жүржэн хувийн цэцэрлэг нь төсвийн төслийн саналаа өгдөггүйгээс Сангийн яамнаас санхүүжилт дутуу ирж байна. Бид энэхүү асуудлыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвлөлдөж төсөвт зохицуулалт хийн хувьсах зардлын дагуу тооцон бодож олгосон. Мөн түүнчлэн Насан туршийн боловсролын байгууллагын 2017 оны санхүүжилт дутуу ирсэн бөгөөд 2018 онд тухайн байгууллагын саналын дагуу санхүүжилт ирсэн болно. Цаашид төсөвт зохицуулалт хийхдээ төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан ажиллана.</p> <p>3.1. Нэгж байгууллагын төсвийн төслийн саналыг тухайн байгууллагын саналын дагуу нэгтгэн БСШУЯаманд хүргүүлдэг. Харин сангийн сайдын баталсан төсвийг хуваарилахдаа боловсролын систем дэх статистик тоон мэдээлэлд үндэслэн цэцэрлэг болон сургуулийн дотуур байрны хоолны зардал, үдийн цайны зардлыг Засгийн газрын 106, 194 тогтоолын дагуу нэг хүүхдэд ногдох нормативаар тооцон хуваарилан ажиллаж байна. Мөн түүнчлэн тухайн зардал нь хүүхдийн ирцээс шууд хамаарах тул улирал, хагас жил, жилийн эцсээр зардлын хэмнэлт үүсдэг бөгөөд хэмнэгдсэн зардлыг төсвийн тухай хуулийн 6.4.8 болон БСШУСЯамны сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 1а/11253 тоот албан бичгийн дагуу ажиллах зорилгоор шаардлагатай зардалд шилжүүлэн хуваарилан ажиллаж байна.</p> <p>3.2. Боловсролын салбарын сар, улирлын санхүүжилтийг “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 2-р хавсралт ЗЭБ-2 маягтын дагуу хийж гүйцэтгэн сар болгон олгодог. Цаашид Засгийн газрын 2016 оны 242-р тогтоолын сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлалын 3.12-т заасны дагуу сар бүр хүүхэд өдрөөр нь хянан ажиллах болно. Нэгж байгууллагуудын аудитаар баталгаажсан тайланг шилэн дансны цахим хуудаснаас харж танилцахад тухайн байгууллагууд шилэн дансанд мэдээллээ бүрэн гүйцэт байршуулдаггүй нь илэрч байна. Иймд цаашид боловсролын салбарын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг бидэнд мэдэгдэж хамтран ажиллана уу.</p> <div style="text-align: center;">  <p>ДАРГА <i>С. Мөнхцэцэг</i> С.МӨНХЦЭЦЭГ</p> </div>	<p>Төрийн бус өмчийн СӨБ, ЕБС- ийн төсвийн төслийг бүрэн авч чадаагүйтэй холбоотой. НТБ-ын төсвийн саналыг 2017 онд 110.7 сая төгрөгөөр өгснийг 109.6 сая төгрөгөөр баталжээ. Тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.</p> <p>3.1. Төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, бүртгэн тайлагнахдаа “Төсвийн тухай” хуулийн 22.1¹⁴-ийг баримтлана. Энэ талаар тайлангийн 1.1, 1.2-д тусгасан.</p> <p>3.2. Хувьсах зардлын санхүүжилтад тавих хяналтын талаар тайлангийн 3.2-т тусгасан.</p>
---	---

¹⁴ 22.1. Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ШИЙДВЭР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 дугаар сарын 30

Дугаар 20

Чингис хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 2.4, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хэнтий аймгийн боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэгт даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Д.Оюунтуяад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН НЭГТГЭЛ

№	Зөрчлийн агуулга	Алдаа зөрчлийн		Үүнээс:			
		тоо	Дүн /сая.төг/	зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн
1	ЕБС-иуд төсвийн төсөл боловсруулахдаа 2017 онд 1631,4 сая төгрөг, 2018 онд 1536,7 сая төгрөг илүү төсөвлөсөн	5	3138,1	✓		✓	
2	Төрийн бус өмчийн ЕБС төсвөөс авах татаасыг 2017 онд 42.1, 2018 онд 2.2 сая.төг-өөр илүү тооцсон	1	44,3	✓		✓	
3	НТБ олгох төсвийн төслийг 2017 онд 995,8 сая төгрөг, 2018 онд 789,5 сая төгрөгөөр илүү төсөвлөсөн	2	1785,3	✓		✓	
4	Аймгийн БСУГ 2017 онд 413,8 сая төгрөг, 2018 онд 614.3 сая төгрөгөөр ЕБС-иудын төсвийн төслийг илүү хянасан.	5	1028,1	✓		✓	
5	Аймгийн БСУГ 2017 онд 146,8 сая төгрөг, 2018 онд 151,9 сая төгрөгөөр НТБ олох төсвийг илүү хянасан.	2	298,7	✓		✓	
6	Сангийн сайдын зөвшөөрөлгүй ЭЗ-гийн ангиллын хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан.	1	0	✓		✓	
7	ТШЗ-ийн төсвийг санал, үндэслэлгүй бууруулсан	1	0	✓		✓	
8	ТШЗ-ийн төсвийн зардлын бүлэг хооронд 20%-аас илүү хэмжээний зохицуулалт хийгдсэн.	1	0	✓		✓	
9	СТА-аар СӨБ-д 23.9, ЕБС-д 46,0 сая төгрөгийн зөрчил илэрсэн	2	69.9	!			
10	Хувьсах зардлын дундаж нормативт зардлын санхүүжилтийг аймгийн БСУГ сар бүр хянаагүй	1	0	✓			
11	Шилэн дансанд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлээгүй	2	0	!			
	ДҮН	23	6364,4				

ХАВСРАЛТ

Хавсралт 8 - Аудитын асуулт, дүнгийн маягт

Хавсралт 9 – Аудитаар илэрсэн нийт асуудлын бүртгэл

Хавсралт 10 – Гүйцэтгэлийн аудитын материаллаг илрүүлэлтийг шинжлэх хүснэгт

Ажлын баримт 01 – Бүлэг дүүргэлт ба багшийн хангамж

Ажлын баримт 02 – Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх 2017

Ажлын баримт 03 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх 2018

Ажлын баримт 04 – Дотуур байрны зардал, хүүхдийн хоол

Ажлын баримт 05 – Орой, эчнээ сургалтын зардал

Ажлын баримт 06 – Насан туршийн боловсрол

Ажлын баримт 07 – Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилт

Ажлын баримт 08 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 2017, 2018

Ажлын баримт 09 – Нэг удаа олгох мөнгөн тэтгэмж, урамшил

Ажлын баримт 10 – Улирлын ажлын үр дүнгээр олгох урамшуулал

Ажлын баримт 11 – Бусад зардал

Ажлын баримт 12 – Төсвийн хуваарь 2017 он.

Ажлын баримт 13 – Төсвийн хуваарь 2018 он

Ажлын баримт 14 – Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Ажлын баримт 15 – Төсвийн боловсруулалт, хяналт, хуваарилалтад хийсэн дүн шинжилгээ